



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/358

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/358 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/149 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Томуугаас сэргийлье” уриан дор дархлаажуулах ажлыг дүүрэгт 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд чанар үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсэг (Х.Ганбат)-т үүрэг болгосугай.

2.Дархлаажуулалтын 10 хоног зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд жирэмсэн эмэгтэйчүүд, зорилтот бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын ажилтан албан хаагчид, эцэг эх асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-5 насны хүүхэд, заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 0-15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулахыг Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч (Н.Тунгалаг, С.Отгонтуяа, Ц.Цэцгээ), Хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 11 ны өдрийн
10 дугаар захирамжийн хавсралт



**ДАРХЛААЖУУЛАЛТЫН 10 ХОНОГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн
Ахлагч:

Х. Ганбат

Эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд:

Н.Нямзав

1 дүгээр хорооны Засаг дарга

Б.Батзориг

2 дугаар хорооны Засаг дарга

Н.Тунгалаг

44 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

С.Отгонтуяа

207 дугаар цэцэрлэгийн
эрхлэгч

Ц.Цэцгээ

183 дугаар цэцэрлэгийн
эрхлэгч

Д.Дашдэлэг

Хүүхдийн их эмч

Нарийн бичгийн
дарга:

М.Оюунтүлхүүр

Вакцинатор сувилагч